



ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ  
НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОДОНЧИМЭГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,

Сайнцагаан сум, Нарлаг баг

Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08

E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.04 № 01/163

Зөрчил арилгуулах тухай

Аймгийн Аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Төв номын сангийн 2016 оны гуравдугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрлын аудитаар **124,500.00 /Нэг зуун хорин дөрвөн мянга таван зуун/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Уүнд:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй 112,500 төгрөгийн бэлэн мөнгийг зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайландаа тусгахыг хориглоно/*-д заасныг;

2. ЗДТГ-ын томилотоор ажилласан ажилтанд 12,000.00 төгрөгийн албан томилолт олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/*, мөн Сангийн сайдын 1992 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Албан томилолтын зардлын тухай” журмын 6-д /*Албан томилотоор ажилласан хүмүүст байр, зам хоног, уналгын зардлыг уг хүнийг томилсон байгууллагаас олгоно/*/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /*Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /*Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжсээч, аудитор, шинжсээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1 /*Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох стандарт, журам шаардлагын дагуу зохих ёсоор хөтөлөөгүй /, 4.1.3-д /*Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулат бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/* заасныг тус тус үндэслэн*

1101000712

## ШААРДАХ НЬ:

- Хүчин төгөлдөр, иж бүрэн анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэж, үнэн зөв тайлагнаж байх, мөнгөн гүйлгээний тайланг хянаж, баталгаажуулж хэвших;
- Төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж, дотоод хяналтыг сайжруулах.
- Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Номын сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч /Ц.Одончимэг/, нягтлан бодогч /А.Эрдэнэмөнх/ нарт хариуцуулав.

## АЛБАН ШААРДЛАГЫГ

### ӨГСӨН<sup>1</sup>:

Аудитор  Т.Оюунэрдэнэ



### ЗӨВШӨӨРСӨН:

#### Номын сангийн:

Захирал  Ц.Одончимэг  
Нягтлан бодогч  А.Эрдэнэмөнх



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулхаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.